



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 27 өдөр

Дугаар А/639

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187, 2023 оны А/133 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмшигч иргэн Тугч овгийн Бямбабаатарын Нарангарав (РЭ91062009)-ын Мөрөн сум 7 дугаар баг 33-12а тоотод байршилтай 6712016617 нэгж талбарын дугаартай 280м² гэр, орон сууцны хашааны газрын зориулалтаар эзэмшүүлсэн газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа дууссан тул өөрийнх нь хүсэлтийн дагуу 40 жилийн хугацаагаар сунгаж эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/643 дугаар захирамжийн хавсралтын 1 дэх заалтын холбогдох хэсгийг хүчингүй болгосугай.

3. Захирамжаар газар эзэмшигч иргэн Тугч овгийн Бямбабаатарын Нарангарав (РЭ91062009)-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР